

## АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙР СУУРЬ (Төсөл)

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг Төрийн бус байгууллагын тухай 1997 оны хуулиар баталгаажуулсны үр дүнд хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх ёсыг бэхжихэд чамгүй ахиц дэвшил гарсан билээ. Уг хууль үйлчлэх 20 гаруй жилийн хугацаанд иргэдийн зохион байгуулалттай, сайн дурын нэгдэл нь хүний эрхийн зөрчил, авлига, шударга бус байдлын эсрэг томоохон хүч болж чадахыг нийгэм, төрд хүлээн зөвшөөрүүлж чадлаа.

Гэхдээ Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдах цаг үетэй харьцуулбал өнөөдөр нийгэм, эдийн засгийн харилцаа нарийн төвөгтэй болж, тус хуулийн зохицуулагдаагүй асуудлууд үүсч байна. Тухайлбал, төрийн бус байгууллага нэрээр ашиг олох буюу хуваарилах, нийгмийг хагалж, хүчирхийлэлд уриалан дуудах, шашны болон улс төрийн намын үйл ажиллагаа эрхлэх зэргээр иргэний, хүмүүнлэг нийгэмд харш үзэгдлүүд гарч байна. Иймд ТББ-ын эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх шаардлагатай байгааг бид хүлээн зөвшөөрч буй боловч Хууль зүйн яамнаас санаачлан боловсруулсан Ашгийн бус байгууллагын тухай хуулийн 2019 оны 8 дугаар сарын төсөл нь иргэдийн эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг дараах үндэслэлээр хангаж чадахгүй байна.

1. *Төрийн бус байгууллагуудыг төрөөс хараат болгох эрсдэлд хүргэж байна.* Учир нь хуулийн төсөлд Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийг 9 иргэний төлөөлөлтэй байгуулж, Ерөнхий сайд батламжлахаар тусгаж, ТББ-уудын үйл ажиллагаа, санхүүжилтийг хянах, үнэлэх, дүгнэх зэргээр дотоод асуудалд нь оролцох өргөн эрх мэдлийг олгосон байна.
2. *Хуулийн дагуу ажиллаж буй төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа зогсох эрсдэлтэй байна.* Учир нь тус хуулиар “төрийн бус байгууллага” гэсэн ойлголтыг үгүй болгож, “ашгийн бус байгууллага” гэдгээр шинэчлэн бүртгүүлэх шаардлагыг тавьсан байна. Мөн нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй байгууллагуудыг заавал гишүүнчлэлтэй байгууллага буюу “холбоо”-ны зохион байгуулалтанд орохыг тулгажээ.
3. *Төрийн бус байгууллагууд санхүүжилтгүй болох эрсдэлтэй байна.* Тус хуулийн төсөл нь ТББ-уудын санхүүгийн эх үүсвэрийг хязгаарлах, хянахад чиглэсэн байна. Хэдийгээр “Иргэний нийгмийн хөгжлийн сан” байгуулах тухай заасан боловч төр санхүүжүүлэхийг үүрэг болгоогүй бөгөөд тус сангийн гол эх үүсвэр нь олон улсын байгууллагын хандив тусламж байхаар зохицуулжээ.
4. *Төрийн бус байгууллагуудын олон жилийн туршилага, мэдлэг төрийн бодлогод тусах боломжгүй болж байна.* Хуулийн төслөөр мэргэжлийн холбоодод төрийн бодлого, шийдвэр боловсруулахад оролцох давуу эрхийг олгож байгаа нь төрийн бодлого хөндлөнгийн хяналтгүй зөвхөн мэргэжилтнүүдийн явцуу туршлагаар шийдэгдэхэд хүргэж болзошгүй байна.

Иймд ТББ-ын төлөөллүүд бид иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулаагүй “Ашгийн бус байгууллагын тухай” хуулийн төслийг УИХ-д энэ хэлбэрээр нь өргөн барихыг дэмжихгүй байна.